

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/15/СТА-ТӨҮГ

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани

Агуулга

1 Аудитын гэрчилгээ	3
2.Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл	8
2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ...	9
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	12
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	13
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	13
3. Менежментийн захидал	14
Орлоготой холбоотой асуудал	14
Бараа материалтай холбоотой асуудал	15
Зардалтай холбоотой асуудал	15
Баланстай холбоотой асуудал	16
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	18
4.4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	18
4.4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	20
4.4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	21
4.4.4 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	23
4.4.5 Аудит хийсэн Зорилтот түвшин	24
5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	27



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

Г "ДАРХАНЫ ДУЛААНЫ ЦАХИЛГААН"
СТАНЦ" ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Н.ЧИМЭДДОРЖ ТАНАА

2018.03.15 № 06/459
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар "Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсээр хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

"Дарханы дулааны цахилгаан станц" ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Н.Чимэддорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангуудад аудит хийлээ.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, СТОУС түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 10–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15- ны өдөр эцэслэн баталгаажуулж, “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, “Дундманхайдай аудит” ХХК-ийн аудитор Ж.Бямбажав, туслах аудитор З.Мандах нар хариуцаж хэрэгжүүлэв.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь 2018 оны санхүүгийн тайлангаа “Дундманхайдай аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 15- ны өдрийн 1/158 дугаар бүхий албан бичгийг ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь Хэрэглэгчээ дээдэлсэн найдвартай үйлдвэрлэгч компани байна гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Тус цахилгаан станц нь хувьсах цахилгаан эрчим хүчийг боловсруулж, 6 киловольт хүчдэлийг 110/35 киловольтын түвшинд өсгөж агаарын шугамаар Эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдон Монгол Улс, Дархан-Уул аймгийн аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цахилгаан, дулаан эрчим хүч, усан хангамж, технологийн хэрэгцээний уураар хангадаг.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэл нь:

- - Цахилгаан үйлдвэрлэх
- - Дулаан үйлдвэрлэх
- - Дулаан түгээх
- - Цахилгаанаар зохицуулалттай хангах
- - Дулаанаар зохицуулалттай хангах
- - Дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулж байна.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Компанийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Нийгмийн даатгал тухай хууль
- Татварын багц хууль
- Эрчим хүчний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод

хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус компанийн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Интерактив би-ай” ХХК-ийн боловсруулсан Diamond 5.0 програм хангамж ашигладаг байна.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулга тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь орлогын дэлгэрэнгүй тайланд тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийт зардал бодитоор илэрхийлэгддэгтэй холбоотой юм.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 42,424.1 сая төгрөг бөгөөд түүний 0,2 хувь болох 84.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэлийн үе шатанд тогтоосон нийт 8 эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 11 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээлэл

Аудитын явцад санхүүгийн тайлагналтай холбоотой залруулга хийгдээгүй болно.

Харин үйлдвэрлэлийн өртөг зардалд урлагын арга хэмжээний зардал, хоолны хөнгөлөлт, шагнал, баяр ёслолын арга хэмжээний зардал, эмчилгээний зардал, биеийн тамирын арга хэмжээний зардал, хүлээн авалтын зардал, болзолт уралдааны шагналын зардлуудыг оруулж тооцсон зөрчлийн асуудлыг Эрчим хүчний салбарын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Эрчим хүчний зохицуулах хорооны тарифын аргачлалд бүх эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын ажиллагсдын нийгмийн зардлыг 100 хувь цахилгааны зардлын өртөгт шингээж тооцдог аргачлал мөрдөж ажилладаг тул үйлдвэрлэлийн зардлаар тооцдог гэсэн үндэслэлээр зөрчлөөс хасч шийдвэрлэсэн.

2.8.2 Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	48.9	
3	Албан шаардлага өгсөн	1	15.2	
	Дүн	5	64.1	

2.8.2.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.8.2.1 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт

2018 оны Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ерөнхий төлөвлөгөөнөөс харьцуулалтын аргаар сонгон шалгаруулсан материалыг хянан шалгахад 15.2 сая төгрөгийн худалдан авалт холбогдох журамтай нийцээгүй, баримт бичгийн зөрчилтэй сонгон шалгаруулалт хийгдсэн байна. Энэ нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө", 4 дүгээр зүйлийн 4.1.2-т "50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд захиалагч байна", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараахь эрх, үүрэгтэй байна", 46.1.4-д "Худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах", 46.1.6-д "Бараа ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдэл:

Анхан шатны баримт бүрдлийг хангаж ажиллах, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийг мөрдөн ажиллах албан шаардлага хүргүүлэх

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

1. Монгол улсын Засгийн Газрын 193 тоот тогтоол, Сангийн сайдын 207 тоот тушаал, ТӨБЗГазрын даргын 367 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “тус компани нь газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний ажлыг зохион байгуулж 36,462.5 сая төгрөгийн дахин үнэлгээ хийж үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлээр бүртгэж үндсэн хөрөнгөө нэмэгдүүлж бүртгэсэн байна.Үүнд:

-Барилга байгууламж 13,859.4 сая төгрөгөөр нэмэгдэж, 404.7 сая төгрөгөөр бууруулан хөрөнгийн дахин үнэлгээний дансанд бүртгэсэн байна.

-Газар эзэмших эрхийг 22,603.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн биет бус хөрөнгөнд бүртгэн төрийн өмч дансанд капиталжуулсан байна.

2. Тус компани нь нягтлан бодох бүртгэлд зардлыг оновчтой ангилж хуримтлуулан бүртгэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн өртгийг үнэн зөв, бодитой тооцоолсон, дотоод хяналттай холбоотой горимуудыг хэрэгжүүлж буй эсэх,

3.Турбины шинэчлэлийн төслийн хүрээнд авсан 20.0 сая еврогийн зээлийн ханшийн бодит бус алдагдал нь тус компанийн санхүү төлбөрийн чадварт шууд нөлөөлж ханшийн зөрүүнээс ихээхэн хэмжээний мөнгийг төлөх эрсдэл үүссэн байгаа тул ханшийн зөрүүний алдагдлыг зээлийн төлбөрөөс чөлөөлөх талаар холбогдох дээд газруудад тавьж шийдвэрлүүлсэн эсэх,

4.“Дулаан Шарын Гол” Орон нутгийн өмчит компаниас авах 209.1 сая төгрөгийн найдваргүй авлагыг барагдуулах арга хэмжээ авсан зэрэг ажлуудыг дараагийн аудитаар нягтлан авч үзэх нь зүйтэй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар тус компанийн удирдлага нь батлагдсан зорилтот түвшин, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Тус компанийн 2018 оны эдийн засгийн зорилтот түвшингийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн байдлыг товч харуулвал:

1.Бүтээгдэхүүний үйлдвэрлэл

Цахилгаан эрчим хүчний түгээлтийг 218,430.2 мянган квт цаг төлөвлөснөөс 218896.7 мянган квт цаг түгээж зорилтот түвшингээс 466.6 мянган квт цаг илүү үйлдвэрлэж 100,2 хувь, дулааны эрчим хүчийг 517.5 мянган Гкал төлөвлөснөөс 519.7 Гкал түгээж 100.4 хувь тус тус биелүүлсэн байна.

2.Тус компанийн 2018 оны гол үзүүлэлтийг харьцуулж үзвэл:

Төлөвлөгөөгөөр 39,002.8 сая төгрөгийн борлуулалтын орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 39,098.4 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнаж төлөвлөгөөг 100.2 хувиар биелүүлж ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны зардал төлөвлөгөөгөөр 39,973.3 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 39,446.7 сая төгрөгийн зардал гарган төлөвлөгөөг 98.7% буюу 526.6 сая төгрөгөөр бууруулсан байна. Энэ нь тогтмол зардлыг 507.0 сая төгрөгөөр, түлшний зардлыг 20.0 сая төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна. Зардлын бүтцийг судалж үзвэл түлшний зардал 16,977.0 сая төгрөг буюу 43.0 %-г эзэлж, тогтмол зардал 22,469.3 сая төгрөг буюу 57 %-г эзэлж байна. Үндсэн үйлдвэрлэлийн зардлын 24,307.4 сая төгрөг буюу 61.6 хувь нь цахилгаанд, 15,138.9 сая төгрөг буюу 38.4% хувь нь дулаанд ноогдож байна.

Үйл ажиллагааны 31 нэр төрлийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэлгүй бүрэн хэмнэж ажилласан байна.

Нийт үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөгөөр 970.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаас 348.3 сая төгрөгийн алдагдалтай ажиллаж, 622.2 сая төгрөгөөр алдагдлыг бууруулсан.

Нийт орлого гүйцэтгэлээр 40,598.3 сая төгрөгийн орлого олж нийт зардал 42,424.2 сая төгрөгийг зарцуулан 1,825.8 сая төгрөгийн балансын алдагдалтай тайлагнасан байна. Энэ нь Турбин-5 төслийн еврогийн ханшийн бодит бус ашиг, алдагдлын /1,823.6-3,659.1/ ханшийн зөрүү 1,835.4 сая төгрөг нөлөөлсөн байна.

3. Өр авлагын талаар.

Нийт авлага 2,340.7 сая төгрөг оны эхнээс 298.5 сая төгрөгөөр өссөн нь цахилгаан эрчим хүчний борлуулалтын авлага 369.9 сая төгрөгөөр өссөн байна. Авлага өссөн шалтгаан нь Улаанбаатар хотын гэр хорооллын шөнийн тарифыг тэглэсэнтэй холбоотойгоор төсвөөс орж ирэх цахилгааны татаасын мөнгө ороогүй нь нөлөөлсөн байна. Дулааны эрчим хүчний борлуулалтын авлага 50.8 сая төгрөгөөр буурсан ба бусад байгууллага аж ахуйн нэгжээс авах авлага 5.2 сая төгрөгөөр бууруулсан байна.

Богино хугацаат өглөг 2018 оны эхэнд 1,823.9 сая төгрөг байснаас оны эцэст 3,544.7 сая төгрөг болж 1,720.8 сая төгрөгөөр өссөн. Банкны богино хугацаат зээлд 1,460,6 сая төгрөг аж ахуйн нэгж байгууллагуудад 2,084.2 сая төгрөгийн өглөгтэй байна. Богино хугацаат өглөгийн гүйцэтгэлийг ТӨБЗГ-аас баталсан зорилтот түвшинтэй харьцуулахад 1,888.2 сая төгрөгөөр өссөн нь 1 дүгээрт, ЭХЗХороо оны эцэст нэг худалдан авагчын алдагдалд 1,322.9 сая төгрөгийг борлуулалтыг татан авсан, 2 дугаарт “ДҮТ” ТӨХК-аас 369.9 сая төгрөгөөр хуримтлагдсан авлага нэмэгдэж өглөг өсөхөд нөлөөлсөн.

4. Урт хугацаат өр төлбөрийн талаар

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн санхүүгийн тайланд 2018 оны жилийн эцсийн байдлаар нийт 70,314.4 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр бүртгэлтэй

байна. Үүнээс 53,916.4 сая төгрөг нь гадаадын урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэл, үлдсэн 16,398.0 сая төгрөг нь дотоодын эх үүсвэр Монгол талаас гаргасан хөрөнгө оруулалтын үлдэгдэл байна.

Компанийн урт хугацаат өр төлбөрийн дансанд 6 төслийн, 53,916.4 сая төгрөг байна. Ангилбал дараахь байдалтай байна.

Д/д	Төсөл арга хэмжээ	Зээлийн үлдэгдэл 2018 оны /12/31 /сая. төгрөг/	Хөрөнгө оруулагч	Төсөл хэрэгжиж эхэлсэн ба дуусах хугацаа	Зээл төлж эхлэх хугацаа	Төслийн үр дүн
1	Турбин-5 төслийн зээл	51,569.0	ХБНГУ Сэргээн босголт банк	2011-2019	6/1/2018	Төслийн ажил энэ онд дуусна.
2	Дархан-1- 9365255	1,022.8		1993-1995	2001-2028	1993-1996 онд ЭХ-ний түгээлт 63.9-149.1 сая квт/ц болж нэмэгдсэн, дотоод хэрэгцээний ЦЭХ-ний зарцуулалт 33.2-20.3 хувь, мазутын хэрэглээ 1,956.2-484.4 тн болж буурсан.
3	Дархан-2 -9585862	510.0		1995-1997	2005-2030	
4	Бараа төсөл9365123	169.5		1993-1996	2001-2028	
5	Эрчим хүчний хөтөлбөр-1 төслийн багц-2,1 ТБЦДС ЖК	612.6		2008-2010	2009-2030	Тоноглолын найдвартай ажиллагаа сайжирсан. тогтмол гүйдлийн систем шинэчилснээр станц хувьса х хүчдэлгүй болж өөрийн хэрэгцээний гэрэлтүүлгийг хэвийн хүчдэлтэй болох хүртэл бүрэн хангах болсон.
6	Эрчим хүчний хэмнэлт УБДС	32.5	Азийн хөгжлийн банк	1998	2012-2031	Механик тоолуур электрон болж шинэчлэгдэн нарийвчлалын алдаа 2%-с 0.5 болж буурсан.
	Нийт дүн:	53,916.4				

2.11. Шилэн дансны мэдээлэл

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг “shilendans.gov.mn” цахим хуудсаар “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр ил тод мэдээлж ажилласан байна. Үүнд:

1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл -12 удаа

2.Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр -12 удаа

3.Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл - 12 удаа

4.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан -1 удаа

5.Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл -12 удаа

6.Концессийн мэдээлэл-12 удаа тус тус мэдээлж тайлагнасан байна.

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 5 зөвлөмж өгөгдсөнөөс 98 хувийн биелэлттэй байна.

МУ-ын ЗГ-ын 196 дугаар тогтоол, ТӨБЗГ-ын даргын А-1/3549 дүгээр албан бичгийн дагуу үл хөдлөх хөрөнгө, газрын ангилал, үндсэн тоноглолын ангиллыг НББ-ийн СТОУС-ын дагуу болгож, санхүүгийн тайлагналын зориулалтаар үнэлгээ хийгдэж бэлэн болж байна. Харин бусад үндсэн хөрөнгийн хувьд 2019 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан үнэлгээний ажил үргэлжлэн хийгдэх бэлтгэл ханган ажиллаж байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Орлоготой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд үндсэн бус үйл ажиллагааны буюу цайны газар, Оч сувилалын орлого 18.3 сая төгрөгийг борлуулалтын орлогоор бүртгээгүй байна.

Энэ нь “Иж бүрэн байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичилт хийж бүрдүүлнэ”, 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал тусгана”, 14.4.2-д “ бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтуудтай нийцээгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, орлогыг бүрэн бүртгэж тайлагнах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулсан болно.

Бараа материалтай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Бараа материалын дансаас анхан шатны баримт бүрдэлгүй 11.2 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

